



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/107

Ховд

“Тэргүүний” сум, байгууллага
шалгаруулах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3, аймгийн Засаг даргын 2017 оны А/347 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын Тамгын газраас сум, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн дүнгээр 2020 оны ажлаараа шалгарсан “Тэргүүний” сум, байгууллагын байр эзэлсэн байдал, мөнгөн урамшууллын хэмжээг 1 дүгээр, шагналд зарцуулах хөрөнгийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. “Тэргүүний” сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, байгууллагын даргыг үндсэн цалингийн 100 хувиар, дэд, гутгаар байр эзэлсэн сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, байгууллагын дарга нарыг үндсэн цалингийн 75 хувиар шагнаж, урамшуулахыг тухайн сум, байгууллагын дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3. Шагналын үнэд зарцуулах 4 900 000 төгрөг (Дөрвөн сая есөн зуун мянган)-ийг 2 дугаар хавсралтаар баталж, Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/107 Ch
02 0747


Аймгийн Засаг даргын 2021 оны
02 дугаар сарын 23-ны өдрийн
А/107 дугаар захирамжийн 1 дүгээр
хавсралт

ТЭРГҮҮНИЙ СУМ, БАЙГУУЛЛАГУУДЫН
БАЙР ЭЗЭЛСЭН БАЙДАЛ

Д/д	Сум, баг, аж ахуйн нэгж, албан байгууллагын нэр	Эзэлсэн байр	Мөнгөн урамшуулал /төгрөг/
Тэргүүний сум			
1	Дарви	Аймгийн 2020 оны тэргүүний сум	1 000 000
3	Чандмань	Аймгийн 2020 оны тэргүүний сум	500 000
4	Ховд	Аймгийн 2020 оны тэргүүний сум	500 000
Албан байгууллага			
1	Онцгой байдлын газар	Аймгийн 2020 оны ажлаараа тэргүүлсэн байгууллага, хамт олон	1 000 000
2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Аймгийн 2020 оны ажлаараа тэргүүлсэн байгууллага, хамт олон	500 000
3	Мал эмнэлгийн газар	Аймгийн 2020 оны ажлаараа тэргүүлсэн байгууллага, хамт олон	500 000
Нийт дүн			4 000 000

-oOo-

Аймгийн Засаг даргын 2021 оны
02 дугаар сарын 23-ны өдрийн
А/107 дугаар захирамжийн 2 дугаар
хавсралт



ТЭРГҮҮНИЙ СУМ, БАЙГУУЛЛАГЫН ШАГНАЛ

Д/Д	Материалын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Туг 120*50	6	25 000	150 000
2	Өргөмжлөл	6	110 000	660 000
3	Батламж	6	15 000	90 000
Бүгд үнэ				900 000

-oOo-